



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын V байр,
Утас/Факс: (976-51) 26 75 33, E-mail: foreign@mojha.gov.mn,
<http://www.mojha.gov.mn>

2018.12.04 № 1-3/5871
танай _____-ны № _____-т

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
ГАЗРЫН ДАРГА Д.МӨРӨН ТАНАА

“Гадаадын иргэний хяналтын улсын
байцаагчийн дүрэмт хувцас, ялгах тэмдгийн
загварыг шинэчлэн батлах тухай” Хууль зүй,
дотоод хэргийн сайдын 2018 оны 12 дугаар сарын
03-ны өдрийн А/221 дүгээр тушаалыг хүргүүлэв.

Хүлээн авч, тушаалыг хэрэгжүүлж
ажиллана уу.

Хавсралт: 6. хуудастай

ДЭД САЙД

Б.ЭНХБАЯР



Бүрэлтэл аваач
хэрэгжүүлж
но хэрэгжүүлэх.

08 6731
Doc.yam a5.2018

Шорин 11/6.



МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 12 сарын 23 өдөр

Дугаар А/221

Улаанбаатар хот

Дүрэмт хувцас, ялгах тэмдгийн загварыг
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн дүрэмт хувцас, ялгах тэмдгийн загвар"-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан "Журам шинэчлэн батлах тухай" Хууль зүйн сайдын 2016 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/177 дугаар тушаалын 1 дэх хэсгийн "Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний" гэснийг "Гадаадын иргэний" гэж, 2 дахь хэсгийн "Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын дарга /Д.Болд/-д" гэснийг "Гадаадын иргэн, харьяатын газрын дарга /Д.Мөрөн/-д" гэж, мөн тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан "Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний хяналтын улсын байцаагчийн дүрэмт хувцас, ялгах тэмдэг хэрэглэх журам"-ын гарчгийн, 1.1 дэх хэсгийн "Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний" гэснийг "Гадаадын иргэний" гэж, "2.5" дахь хэсгийг "4.10" гэж, 1.2, 4.2, 4.9.2, 4.10 дахь хэсгийн "Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний байгууллагын" гэснийг "Гадаадын иргэний асуудал эрхэлсэн байгууллагын" гэж тус тус өөрчилсүгэй.

3. "Журам шинэчлэн батлах тухай" Хууль зүйн сайдын 2016 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/177 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан "Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний хяналтын улсын байцаагчийн дүрэмт хувцас, ялгах тэмдэгний загвар"-ыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гадаадын иргэн, харьяатын газрын дарга /Д.Мөрөн/-д даалгасугай.



Ц.НЯМДОРЖ

Doc\tushaal Said. 2018

08 0852

Хууль зүй, дотоод хэргийн сайдын
2018 оны 12-р дугаар тушаалын хавсралт

**ГАДААДЫН ИРГЭНИЙ ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧИЙН
ДҮРЭМТ ХУВЦАС, ЯЛГАХ ТЭМДГИЙН ЗАГВАР**

Нэг.Дүрэмт хувцасны бүрдэл

1.1.Малгай:

- 1.1.1.ёслолын саравчтай малгай;
- 1.1.2.өдөр тутмын саравчтай малгай;
- 1.1.3.ноосон малгай.

1.2.Гадуур хувцас:

- 1.2.1.ёслолын хүрэм /эрэгтэй/;
- 1.2.2.ёслолын өмд /эрэгтэй/;
- 1.2.3.ёслолын хүрэм /эмэгтэй/;
- 1.2.4.ёслолын өмд /эмэгтэй/;
- 1.2.5.ёслолын юбка /эмэгтэй/;
- 1.2.6.өдөр тутмын хүрэм /эрэгтэй/;
- 1.2.7.өдөр тутмын өмд /эрэгтэй/;
- 1.2.8.өдөр тутмын хүрэм /эмэгтэй/;
- 1.2.9.өдөр тутмын өмд /эмэгтэй/;
- 1.2.10.өвлийн хүрэм;
- 1.2.11.өвлийн өмд;
- 1.2.12.хавар, намрын богино хүрэм.

1.3.Дан хувцас:

1.3.1.ёслолын цагаан урт ханцуйтай цамц;

1.3.2.богино ханцуйтай цамц;

1.3.3.ноосон цамц;

1.3.4.поло цамц.

1.4.Гутал:

1.4.1.хагас түрийтэй өвлийн гутал;

1.4.2.хагас түрийтэй хавар, намрын гутал.

1.5.Бусад:

1.5.1.тэлээ;

1.5.2.тоногтой суран бүс;

1.5.3.савхин бээлий;

1.5.4.зангиа.

1.6.Ялгах тэмдэг:

1.6.1.малгайн тэмдэг;

1.6.2.зангианы хавчаар;

1.6.3.албан хаагчийн нэрийн бичиглэл;

1.6.4.малгайн соёмботой товч;

1.6.5.ёслолын соёмботой товч;

1.6.6.захын тэмдэг;

1.6.7.ханцуйн тэмдэг;

1.6.8.жетон;

1.6.9.ажлын үнэмлэх;

1.6.10."IMMIGRATION" бичиглэл;

1.6.11.аксалвант.

Хоёр.Дүрэмт хувцасны загвар

2.1.Малгай:

2.1.1.ёслолын саравчтай малгай нь цагаан өнгийн сагалдарга, сагалдаргыг тогтоох зориулалттай малгайн хүрээний хоёр талд байрлах соёмбо дүрстэй жижиг товч, малгайн урд хэсэгт хүрээний доод ирмэгээс 0.5 см зайтай голлуулан байрлуулсан байгууллагын таних тэмдэг /төмөр/-тэй байна;

2.1.2.өдөр тутмын саравчтай малгайн урт талд байгууллагын таних тэмдэг, ар талд "IMMIGRATION" бичиглэл цагаан өнгийн утсаар дүрслэгдсэн байна;

2.1.3.ноосон малгайн зүүн хэсэгт "IMMIGRATION" бичиглэл цагаан өнгийн утсаар дүрслэгдсэн байна.

2.2.Хүрэм:

2.2.1.ёслолын хүрэмний захад "MGL" бүхий дүрс, зүүн ханцуйд "Гадаадын иргэн, харьяатын газар"-ын, баруун ханцуйд "Хууль сахиулагч"-ийн таних тэмдэг, зүүн энгэрт "IMMIGRATION", баруун энгэрт албан хаагчийн нэр алтан шаргал өнгийн бичиглэл;

2.2.2.өдөр тутмын хүрэм, өвлийн хүрэмний зүүн ханцуйд "Гадаадын иргэн, харьяатын газар"-ын, баруун ханцуйд "Хууль сахиулагч"-ийн таних тэмдэг, зүүн энгэр, хойд талд "IMMIGRATION", баруун энгэрт албан хаагчийн нэр цагаан өнгийн бичиглэл;

2.2.3.хавар, намрын богино хүрэм нь хөх өнгийн материалаар хийгдсэн зүүн ханцуйд "Гадаадын иргэн, харьяатын газар"-ын, баруун ханцуйд "Хууль сахиулагч"-ийн таних тэмдэг, зүүн энгэр, хойд талд "IMMIGRATION", баруун энгэрт албан хаагчийн нэр цагаан өнгийн бичиглэл байна.

2.3.Цамц:

2.3.1.урт богино ханцуйтай хар, цагаан цамцны нь зүүн ханцуйд "Гадаадын иргэн, харьяатын газар"-ын, баруун ханцуйд "Хууль сахиулагч"-ийн таних тэмдэг, зүүн энгэрт "IMMIGRATION" бичиглэл;

2.3.2.ноосон цамцны зүүн энгэрт "IMMIGRATION" бичиглэл;

2.3.3.поло цамцны зүүн энгэр болон ар талд "IMMIGRATION" бичиглэлтэй байна.

2.4.Зангиа, тэлээ:

2.4.1.зангианд "IMMIGRATION" бичиглэлийг цагаан өнгийн утсаар дүрсэлнэ;

2.4.2.тэлээний арал дээр байгууллагын таних тэмдгийг дүрсэлнэ.

2.5.Ялгах тэмдэг:

2.5.1.ялгах тэмдэг /жетон/ байгууллагын таних тэмдэг, хувийн дугаар бүхий мөнгөлөг саарал /төмөр/ өнгөтэй байна;

2.5.2.ёслолын хүрэм, малгайн товч нь соёмботой алтан шаргал өнгийн хуванцар болон төмөр материалаар хийгдсэн байна;

2.5.3.ханцуйн "Хууль сахиулагч" тэмдэг нь бамбай хэлбэртэй, дээд талд "ХЗДХЯ", доод талд "ХУУЛЬ САХИУЛАГЧ" гэсэн бичвэрийг кирилл үсгээр, гол хэсэгт бамбай дотор соёмбо, түүний хоёр талд "МОНГОЛ УЛС" гэсэн бичвэрийг монгол бичгээр бичиж, тариан түрийгээр хүрээлсэн байна;

2.5.4.ханцуйн "Гадаадын иргэн, харьяатын газар"-ын тэмдэг нь бамбай хэлбэртэй, дээд талд "MONGOLIA", доод талд "IMMIGRATION AGENCY" гэсэн бичиглэл, гол хэсэгт байгууллагын таних тэмдэг, түүний хоёр талд "МОНГОЛ УЛС" гэсэн бичвэрийг монгол бичгээр бичиж, тариан түрийгээр хүрээлсэн байна;

2.5.5."Хууль сахиулагч", "Гадаадын иргэн, харьяатын газар", ханцуйн тэмдгийг дүрэмт хувцасны төрөл, материалын төрөл, шинж чанарт зохицуулан хийх бөгөөд ёслолын, өдөр тутмын хувцас, хавар, намар, өвлийн хувцас, богино болон урт ханцуйтай цамцны ханцуйн дээд оёдлоос 5-10 см зайтай байрлуулна.

Гурав.Дүрэмт хувцасны материалын шинж чанар

№	Дүрэмт хувцас	Материалын шинж чанар
1.	Ёслолын саравчтай малгай	70% ноос, 30% полиэстрийн холиотой, хар өнгийн даавуу
2.	Өдөр тутмын саравчтай малгай	70% ноос, 30% полиэстрийн холиотой, хар өнгийн даавуу
3.	Ноосон малгай	40% ноос, 60% акрилийн холиотой, хар өнгийн нэхмэлийн давхар утас
4.	Хүрэм, өмд, юбка	70% ноос, 30% полиэстрийн холиотой, хар өнгийн даавуу
5.	Өдөр тутмын хувцас	70% ноос, 30% полиэстрийн холиотой, хар өнгийн даавуу
6.	Хавар намрын богино хүрэм	70% ноос, 30% полиэстрийн холиотой, хөх өнгийн даавуу

7.	Өвлийн хувцас	100% полиэстрийн холиотой, хар өнгийн даавуу
8.	Ноосон цамц	40% ноос, 60% акрилийн холиотой, хар хөх өнгийн нэхмэлийн утас. Мөр, тохойн хэсгийг даавуу
9.	Поло цамц	70% хөвөн, 30% акрилийн холиотой, хар хөх өнгийн хөвөн даавуу
10.	Сорочкан цамц	85% хөвөн, 12 % полиэстрийн холиотой, 3% суналттай, хар болон цагаан өнгийн даавуу
11.	Гутал /өвлийн/	хар өнгийн арьс, хонины нэхий болон зориулалтын дулаалгын материал
12.	Гутал /хавар, намрын/	хар өнгийн арьс, зориулалтын материал
13.	Жетон, малгайн тэмдэг, зангианы хавчаар	Мөнгөлөг саарал өнгийн төмөр
14.	Зангиа	Хар өнгийн торгон даавуу
15.	Бээлий	Хар өнгийн торгон савхи
16.	Тэлээ	Хар өнгийн зориулалтын шир, никел төмөр арал
17.	Тоногтой суран бүс	Хар өнгийн 5 мм зузаантай, зориулалтын шир, хоёр шүдтэй, никел төмөр арал
18.	Захын тэмдэг, товч	Алтан шаргал өнгийн төмөр

...oOo...